



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 15 өдөр

Дугаар 1/349

Улаанбаатар хот

Г Сонгинохайрхан дүүргийн 80 дугаар Г
цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг
балансаас балансад шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/82 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2024 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 9 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 3,500,000.00 (гурван сая таван зуун мянга) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Баянзүрх дүүргийн 319 дүгээр цэцэрлэгт хавсралтын дагуу шилжүүлж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн 80 дугаар цэцэрлэг (Б.Ганцэцэг)-т зөвшөөрсүгэй.

2.Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг баримтлан хавсралтын дагуу бүртгэж авах, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн 319 дүгээр цэцэрлэг (Н.Энхчимэг)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт, ашиглалт, дотоод аудитын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *В.Оюумаа* В.ОЮУМАА



Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны 3-р дүгээр сарын 13-ны өдрийн 339 дугаар тушаалын хавсралт

Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн 80 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалт-анд орсон он	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	бүртгэлийн анхны үнэ		Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Шилжүүлэн авах байгууллага
						нэгж үнэ	/ тегрегээр / нийт үнэ			
1	1-р хоолны тогоо	2023	сайн	ш	1	3,500,000	3,500,000.00	1,108,333.27	2,391,666.73	Баянзүрх дүүргийн 319 дүгээр цэцэрлэг
Шилжүүлэх хөрөнгийн нийт дүн							3,500,000.00	1,108,333.27	2,391,666.73	